

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2 Уурхайн ашиглалтын төлөвлөгөө, хүчин чадал	4
1.2.1 Уурхайн ашиглалтын элементүүд	4
1.2.2 Уурхайн ажиллах горим	5
1.2.3 Хүчин чадал	5
1.3 Дэд бүтэц	6
1.3.1 Уурхайн барилга байгууламж	6
1.3.2 Цахилгаан хангамж	7
1.3.3 Усан хангамж	7
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	13
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2026 ОН/	15
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
4.2 Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө	21
4.3 Тэрбум мод тарих арга хэмжээний төлөвлөгөө	21
4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	21
4.5 Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө	21
4.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
4.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
4.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
4.9 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	26
4.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	29
4.11 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	30

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилбол	3
Хүснэгт 2. Ил уурхайн зохиомжлолд тусгасан үзүүлэлтийн хэмжээс	4
Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим	5
Хүснэгт 4. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	5
Хүснэгт 5. Барилга, байгууламжийн жагсаалт	6
Хүснэгт 6. Усан хангамжийн мэдээлэл	8
Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал /2026 он/	16
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
Хүснэгт 9. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	27
Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө	29
Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө	30

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	Дэвжихийн шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Тээлийн шонхор” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011018126 Регистрийн дугаар: 2848376 Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, 14 давхарт Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017700
Төслийн байршил:	Дэвжихийн шохойн чулууны орд нь Монгол улсын засаг захиргааны нэгжийн хувьд Дорноговь аймгийн Өргөн сумын нутаг дэвсгэрт, аймгийн төв Сайншанд хотоос зүүн урагш 50 км, нийслэл Улаанбаатар хотоос зүүн урагш 500 км, Өргөн сумын төвөөс баруун урагш 28 км зайд тус тус оршдог байна.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилбол

№	Уртгаг	Өргөрөг
1	110° 33' 1.93"	44° 37' 1.55"
2	110° 33' 1.91"	44° 36' 36.56"
3	110° 32' 1.91"	44° 36' 36.56"
4	110° 32' 1.91"	44° 36' 53"
5	110° 31' 0"	44° 36' 53"
6	110° 31' 0"	44° 36' 31.56"
7	110° 30' 1.92"	44° 36' 31.56"
8	110° 30' 1.92"	44° 36' 1.55"
9	110° 29' 15.86"	44° 36' 1.57"
10	110° 29' 15.86"	44° 36' 58.57"
11	110° 29' 40.85"	44° 36' 58.57"
12	110° 29' 40.85"	44° 37' 1.57"

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ
ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.2 Уурхайн ашиглалтын төлөвлөгөө, хүчин чадал

Ордын уул-техникийн нөхцөл, хүдрийн биетийн геологийн тогтцыг харгалзан ил аргаар, экскаватор-автосамосвалын хослол бүхий автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглана.

1.2.1 Уурхайн ашиглалтын элементүүд

Ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрсийг Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу 0.3 м зузаантайгаар урьдчилан хуулна. Хуулж бэлтгэсэн шимт хөрс нь ордыг ашиглаж дууссаны дараах нөхөн сэргээлтийн ажилд ашиглагдах юм. Шимт хөрсний овоолгын өндөр нь 3 м байх бөгөөд хажуугийн тогтворжилтын өнцөг нь 25-33 градус байна. Шимт хөрсийг хуурай сэрүүний улиралд хуулах нь тохиромжтой бөгөөд овоолгыг аль болох нөмөр газар хийх ба тийм боломжгүй тохиолдолд шимт хөрсний овоолгыг сууж дагтарштал нь тусгай зориулалтын торон хучилт хийж салхи шуурганд хийсэхээс сэргийлэх болон ургамалжуулж болно. Шимт хөрсийг уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлаас өмнө хуулж овоолсон байна.

Хүснэгт 2. Ил уурхайн зохиомжлолд тусгасан үзүүлэлтийн хэмжээс

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээс
1	Хаалтын доголын өндөр	м	10
2	Олборлолтын өндөр	м	5
3	Ажлын доголын хажуугийн налуу	град	65°



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ
ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4	Ажлын бус доголын хажуугийн налуу	град	60°
5	Ажлын талбайн хамгийн бага өргөн	м	25
6	Налуу траншейн дагуу налуу	‰	80
7	Ажлын бус доголын аюулгүйн берм-(тавцан) –ийн өргөн	м	5

1.2.2 Уурхайн ажиллах горим

Уулын ажил жилд 9 сар үргэлжлэх ба үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүйгээр өдөрт 1 ээлжээр 10 цагаар үргэлжилнэ.

Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, баяжуулах тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.

Уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагын техникийн даалгавар, уурхайн жилийн хүчин чадалтай нь уялдуулан дараах байдлаар ажиллахаар байна.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим

Үзүүлэлт	Х.нэгж	Хоног
Жилд ажиллах сар	сар	9
Календарь хоног	хоног	270
Баяр ёслолын хоног	хоног	10
Цаг агаарын саатал	хоног	13
Жилд ажиллах хугацаа	хоног	247
Ээлжийн тоо	ээлж	1
Ээлжинд ажиллах цаг	цаг	10

1.2.3 Хүчин чадал

“Тээлийн шонхор” ХХК нь “Дэвжих”-ийн ордоос олборлох шохойн чулууг уурхайн дэргэд баригдах шохойн чулуу боловсруулах үйлдвэрт нийлүүлэх бөгөөд үйлдвэрийн хүчин чадал, олборлох тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамааруулан жилд 200.0 мян.тн шохойн чулуу олборлохоор ажлын даалгавар өгөгдсөн бөгөөд тус хүчин чадлаар ордын нөөцийг бүрэн ашиглахад хэт олон жил буюу 124.5 жил ашиглахаар байна. Иймд ТЭЗҮ-ийг 5 жил бүр тодотгох хугацаа, цементийн зах зээлийн үнийн өөрчлөлт /шохойны үнэ/, захиалагч компанийн ажлын даалгавар зэргийг харгалзан жилд 200.0 мян.тн шохойн чулуу олборлохоор эхний 10 жилээр ТЭЗҮ-д тусгагдсан.

Хүснэгт 4. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Ашиглалтын жилүүд	Хүдрийн нөөц		Агуулга %	СаО мян.тн	Хөрс мян.м ³	Кхх мЗ/тн
	мян.м ³	мян.тн				
1-р жил	74.3	200.0	52.2	104.4	24.2	0.12
2-р жил	74.3	200.0	52.9	105.8	32.0	0.16
3-р жил	74.3	200.0	53.1	106.2	38.4	0.19
4-р жил	74.3	200.0	51.9	103.7	45.6	0.23
5-р жил	74.3	200.0	52.3	104.6	46.0	0.23
6-10-р жил	371.7	1,000.0	51.2	512.5	181.1	0.18
Нийт	743.5	2,000.0	51.9	1,037.2	367.3	0.18



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ
ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**




График 1. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө



Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн ерөнхий зураг

1.3 Дэд бүтэц

1.3.1 Уурхайн барилга байгууламж

Уурхай, үйлдвэрийн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах-засварын байр багтах бөгөөд эдгээр нь уурхайн зүүн хойд талд байрлана.

Хүснэгт 5. Барилга, байгууламжийн жагсаалт

№	Нэр	Хийц, бүрдэл	Тоо, ш
1	Боловсруулах үйлдвэр	Сэндвич	1
2	Засвар механикийн хэсэг	Сэндвич	1
3	Автограж	Сэндвич	1
4	Задгай агуулах	Талбай	1
5	Сэлбэг, материалын агуулах	Сэндвич	1
6	Түлшний агуулах	ёмкость	3
7	Тэсрэх материалын агуулах	контейнер	1
8	Лабораторийн байр	Сэндвич	1
9	Харуул хамгаалалтын байр	Сэндвич	1
10	Оффис	Сэндвич	1
11	Амралтын байр	Сэндвич	1
12	Гал тогоо	Сэндвич	1
	Дүн		14



Зураг 3. Ажилчдын байр

Шохой боловсруулах үйлдвэрээс эцсийн байдлаар 1-р зэргийн шохой гарна. Үйлдвэр нь жилд 200,000 тонн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай ба шатаасан шохойн бүхэллэгийг шигшүүрээр оруулж нунтаглалтанд оруулснаар нунтаг болон бүхэл шохойг үйлдвэрлэнэ.



Зураг 4. Шохойн чулуу боловсруулах үйлдвэр

1.3.2 Цахилгаан хангамж

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн 2023-05-11, 2023-10-02-ны №ДО 23/08 тоот техникийн нөхцөлийн дагуу Шохойн чулууны уурхайн гадна цахилгаан хангамжийн зураг төслийг боловсруулсан байна. Дэвжих шохойн чулуу боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийг шинэ трассын схемээр тулгуур №279-өөс уурхай руу 35 кВ-ийн ЦДАШ татаж, төгсгөлд нь 800 кВА чадалтай 35/10 кВ-ын хүчний трансформатор бүхий дэд станц барьж цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

1.3.3 Усан хангамж


Ус хангамжийн эх үүсвэр:

Уурхайн ажилчдын унд ахуйн усны хэрэглээ, зам талбайн усалгаа, ногоон байгууламжийн усалгаанд ашиглагдах усыг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангахаар төлөвлөсөн байна.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ
ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 6. Усан хангамжийн мэдээлэл

Эзэмшигч байгууллага	“Тээлийн шонхор” ХХК
Худаг гаргасан байгууллага	“Говь ундарга” ХХК
Худгийн байршлын солбилцол	110° 30' 53.98" , 44° 37' 17.19"
Цооногийн гүн	116 м
Усны ундарга	1 л/сек



Зураг 5. Гүний худгийн байршлын зураг

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл: Дорноговь аймаг нь Монголын зүүн өмнөд хэсгийн талархаг гадаргатай хэсэгт оршдог. Гэхдээ энд Хутаг уул (1431м), Оцол, Сансар, Их Багадулаан, Аргалант, Хан Баянзүрх хайрхан (1031м) зэрэг уулууд бий, Нутгийн дундуур зүүн хойшоо баруун урагшаа их хотгор газар үргэлжилнэ.


Дорноговь аймгийн нутагт том гол мөрөн, нуур байхгүй, харин газар доорх усны их нөөц бий. Халзан уул, Бусийн Чулууны, Толь булгийн зэрэг рашаан устай. Нутгийн ихэнхэд говийн бор хөрс тархсан бөгөөд элс нилээд байдаг.

Дэвжихийн орд нь Монгол орны физик газарзүйн мужлалаар өмнөд Монголын говийн бүсэд орших ба тэгш талархаг рельефтэй, үнэмлэхүй өндөр далайн түвшинээс дээш 960-1000 м хүртэл өргөгдсөн, тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үнэмлэхүй өндөржилт 960-996,7 м-ийн хооронд хэлбэлздэг байна. Гадаргын хэлбэр дүрсийн хувьд жижиг толгодорхог, жижиг хөндийнүүдээр хэрчигдсэн гадаргуутай. Тухайн дүүрэгт хамгийн өндөр газар нь Сөгдөх уулын шохойн чулуун гарш бөгөөд далайн түвшинээс дээш 996,7 м өргөгдсөн байдаг байна.

Дүүрэг нь говь, хагас цөл нутгаар хүрээлэгдсэн тул физикийн өгөршил хүчтэй явагдаж, түүний үр дүнд бий болсон сэвсгэр хурдас уулын хормойд хуримтлагдаж бэлүүдийг үүсгэдэг ба уулын хажуу бэл, хөндий сайрууд нь өвөрмөц байдалтай гадаргууг үүсгэсэн байна. Ялангуяа Сөгдөх уулын хажуу бэлийг хуурай сайрууд нэн шигүү хэрчиж, газрыг асар их бартаатай болгосон байдаг. Харин Дэвжихийн орд байршиж буй газар нь тал хөндийн харьцангуй тайван рельефтэй ажээ.

Хөрс, хөрсөн бүрхэвч: Тус шохойн чулууны ордын талбайд нам уул, ухаа толгодын хөрсний хэв шинжид хамаарах цөлөрхөг хээрийн сайргархаг бор ба ердийн бор хөрс тархана. Талбайн орчимд хужир мараа элбэг таарах ба зарим хэсэгт жижиг манхан хэлбэрийн элсний бөөгнөрөл үүссэн байдаг байна..

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 6. Хөрсний тархалтын зураг

Ургамлан нөмрөгийн төлөв байдал: Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших Дэвжихийн шохойн чулууны ордын тусгай зөвшөөрлийн талбайн ургамлын аймгийн мужлал

Дорноговь аймгийн Өргөн суманд байрлах Дэвжихийн шохойн чулууны ордын тусгай зөвшөөрлийн талбайн ургамалжил ургамал ургамал-газар зүйн мужлалын хувьд А.А.Юнатовын (1952) ангиллаар [13]:

Евро Азийн хээрийн мужийн: Умард-Говийн цөлийн хээрийн провинцийн: Дорнод говийн цөлийн хээрийн тойрогт хамаарна. Дээрх хуваарилалт дээр үндэслэн 1989 онд Академич Н.Өлзийхутаг Монгол орны ургамалжлыг ургамал газар зүйн 16 тойрог болгон ангилсаны дагуу Дорноговийн цөлөрхөг хээрийн тойргийн баруун захад [10] оршиж байна.

Уг талбайд бүртгэгдсэн зүйл ургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтцийг авч үзэхэд ойм, шивэрсэн, шивлээ, нүцгэн үртэний хүрээний хүрээний зүйл ургамалгүй, далд үртэний хүрээний 24 зүйл (үүнээс нэг талтан 9 зүйл, хос талтан 15 зүйл) байна.


Энд бүртгэгдсэн ургамлаас лууль, үетэн, голгэсэртэн, сонгинын овгууд нь төрөл, зүйлийн тоогоор эхний 4 –д жагсаж байгаа [9, 10] бөгөөд бусад овгууд ганц зүйлтэй байна. Эхний 4 овогт багтах зүйл ургамлууд лицензын талбай орчмын бүх зүйлийн 83.33% -ийг бүрдүүлж байна.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ
ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тус тусгай зөвшөөрлийн талбайд ургаж байгаа 24 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 8 зүйл нэг наст өвслөг ургамал (33.33%), 7 зүйл олон наст өвслөг ургамал (29.17%), мөн 9 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (37.50%) ургаж байна.

Бэлчээрийн ургамлаас малд сайн идэмжтэй Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.), Бор бударгана (*Salsola passerina* Bge.), Зүүнгарын улаан бударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.) Төлөгчдүү боролз (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), Нарийн навчит харгана (*Caragana stenophylla* Pojark.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.) зэрэг ургамлууд байна.

Усзүйн сүлжээ: Уг төслийн талбай нь гадаргын усны тархалтын хувьд Төв Азийн гадагш урсацгүй ай савын Галба-Өөш-Долоодын говийн сав газрын зүүн хойд хэсэгт оршино. Төслийн талбайтай очиж танилцахад талбайн ойр орчим гадаргын ус буюу гол, горхи, булаг шанд байхгүй байсан. Уг сав газар нь Газарзүйн мужлалаар сав газрын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг буюу 96,6% нь манай орны хамгийн хур тунадас багатай, хуурай уур амьсгал бүхий говь, цөлийн бүсэд оршдог. Төслийн талбайн ойр орчимд гол мөрөн, нуур, булаг шанд байхгүй байна.



Зураг 7. Гадааргын усны сүлжээний болон сав газрын ангилалын зураг

Орд орших дүүрэг нь уулс хоорондын хөндий говийн бүсэд хамаарагдана. Дүүргийн гидрогеологийн нөхцөл нь нийлмэл геологийн тогтоц, рельефийн харьцангуй их хэрчигдэл, эрс тэс хуурай уур амьсгалын байдлаар тодорхойлогддог. Чийгийн дутагдалтай, хур тундасны хэмжээнээс ууршилт давамгайлах, газар доорх усны солилцоо хүндрэлтэй зэрэг тухайн дүүрэгт газар доорх ус бүрэлдэн тогтох тааламжгүй нөхцлүүдийг бүрдүүлнэ. Энэхүү нөхцөл шалтгаанууд олон тооны жижиг газар доорх усны линз, давхарга, ай савуудаас тогтсон гидрогеологийн структурт цэнгэгээс давсархаг газар доорх ус үүсэх нөхцлийг бий болгодог ажээ. Бүс нутагт гидрогеологийн хувьд уулс хоорондох хотгоруудад артезийн бассейн, өргөгдсөн нам өндөрлөгтэй уулсын тогтолцооны хүрээнд гидрогеологийн массивуудаас гадна нээлттэй тектоник хагарлуудад усжсан хагарал гэсэн гидрогеологийн структуруудыг ялгаж болно гэж үзжээ.

Уулс хоорондох хотгор, хөндийнүүдийг дүүргэсэн тунамал хурдсын ус агуулах коллектортай гидрогеологийн бассейнуудад нүх сүв, нүх сүв давхаргын ба ан цав давхаргын, дээрхи хотгор, хөндийнүүдийг хүрээлэн өргөгдсөн гидрогеологийн массивуудад ан цав-грунтын, усжсан тектоник хагарал, шилжилтүүдийн бүсэд ан цав судлын төрлийн газар доорх ус тархан тогтсон байна. Уулс хоорондын хотгор, хөндийнүүдээс Дэвжихийн ордоос хойш 5 км зайтай зүүн хойноос баруун, баруун урагш чиглэлтэй өргөн хөндий дэх Авдрангийн сайранд газар доорх усны байгалийн гаршууд (булаг, шанд, худаг)-ын ул мөр байгаа нь тухайн бүс нутгийн гидрогеологийн нөхцөл, газар доорх усны бүрэлдэн тогтох зүй тогтолыг үнэлэх байгалийн шууд шинж тэмдэг болох физик газарзүйн хүчин зүйл болно гэж үзжээ.

Структур тектоникийн хувьд тунамал, бялхмал, хувирмал чулуулгаас бүрдэх бөгөөд эдгээр нь янз бүрийн нас, найрлага бүхий гүний чулуулгийн биетүүдээр зүсэгдсэн, үндсэндээ баруун урдаас зүүн хойшоо чиглэсэн томоохон хагарлууд нь янз бүрийн чиглэлтэй хөндлөн хагарлуудаар хэрчигдсэн, зарим хэсэгт блоклог бүтэцтэй болгосон зэрэг онцлогтой байна. Энэхүү гидрогеологийн атираат массивын бүсүүд болон өөр хоорондоо тектоник хагарлаар зааглагдсан томоохон хагарлын бүсүүд нь газрын доорх усны урсацын хаалтын бүсүүд болох бөгөөд эдгээр томоохон хагарлуудаас салбарласан жижиг хагарлын бүсүүд усжсан байдаг ажээ.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Тээлийн шонхор” ХХК-ний Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших “Дэвжихийн шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаа хэрэгжснээр тухайн бүс нутаг тодорхой хэмжээгээр элэгдэлд орно. Элэгдэл эвдрэлд оруулах гол хүчин зүйл нь авто машины хөдөлгөөнөөс тоос шороо, дуу чимээ үүсэх, барилга байгууламжийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөг удаан хугацаанд дарагдах зэрэг юм.

Мөн төсөл хэрэгжсэнээр байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Агаарын чанар

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Барилга байгууламжын орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- Машин техникийн эвдрэл гэмтэлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Гадаргын болон газрын доорх ус

Төслийн талбайн хөрсөн дэх тоос нь хүчтэй хур борооны урсцаар дамжин хөрсний ус, хөрсийг бохирдуулах гол эх үүсвэр болно. Ялангуяа гадаргын усыг бохирдуулснаар цэвэр усны амьд организмыг хордуулах аюултай. Хөрсний усны бохирдлын байдлыг хяналтын цооног болон уурхайн худгийн усанд шинжилгээхийж байнгын хяналтад байлгавал зохино. Шинжилгээний дүнд усны чанарын үзүүлэлт зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн нөхцөлд мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор холбогдох арга хэмжээ авсны дараа үйлдвэрлэлээ үргэлжлүүлбэл зохино. Мөн уурхайн ахуйн бохир ус алдагдсанаас усны бохирдолд нөлөөлж болзошгүй тул энэ талын сөрөг нөлөөлөл үүсэхгүй байх арга хэмжээ авч

хяналт тавьж ажиллах ёстой. Бохир усыг зөөж тээвэрлэх явцад асгаж хөрс бохирдуулах, мөн зөвшөөрөлгүй цэгт асгах зэрэг асуудал гарахаас урьдчилан сэргийлж ажиллавал зохино.

Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Уурхайн тээвэрлэлтийн тоосжилт, машин техникийн дуу шуугиан, доргио чичиргээ зэрэг нь ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж, тэдний ажиллах таагүй нөхцөлийг бүрдүүлдэг байна. Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосны 10 микроноос бага хэмжээтэй хэсгүүд нь хүний уушги болон амьсгалын замын эрхтнийг өвчлүүлэх гол эх үүсвэр болно. Удаан хугацаанд сөрөг нөлөөтэй орчинд ажилласнаас ажилчдын анхаарал сарних, осолд өртөх, элдэв өвчинд нэрвэгдэж, хөдөлмөрийн чадвараа түр буюу бүр мөсөн алдах зэргээр осол аюултай үр дагаврыг үзүүлнэ. Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдалт, үйлдвэрлэлийнослоос урьдчилан сэргийлж чадна. Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлд нөлөөлөх гол хүчин зүйлүүдийг 2 бүлэгт хувааж болно.

- Физикийн хүчин зүйл (температур, харьцангуй чийглэг, тоосжилт, дуу шуугиан, гэрэлтүүлэг г.м)
- Физиологийн хүчин зүйл (ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвараа түр алдалт)

Иймд физикийн хүчин зүйлүүдийг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ялангуяа тоосжилт ихтэй цехийн асперацийн системийн үйл ажиллагааг тогтворжуулах, агаар орчинд ус уур тоосруулан цацах маягаар тоосжилтыг багасгах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг иж бүрэн автомат удирдлагатай болгох зэрэг арга хэмжээ авахын зэрэгцээ мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллавал зохино.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2026 ОН/

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/618 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ
ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2026 оны БОМТ-д сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 7000000, Тэрбум мод тарих үндэсний хөтөлбөрийн хүрээнд 1500000, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 8000000 төгрөг, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 6000000, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 3500000, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд 1500000 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 1650000 нийт 30650000 төгрөг зарцуулахаар тусгасан.

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал /2026 он/

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Жилийн зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	төгрөг	7,000,000
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	төгрөг	-
3	Тэрбум мод тарих төлөвлөгөөний зардал	төгрөг	1,500,000
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	8,000,000
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	-
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төгрөг	6,000,000
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	төгрөг	3,500,000
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	төгрөг	1,500,000
10	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	төгрөг	1,650,000
11	БОМТ -г орон нутагт тайлагнах	төгрөг	-
	Дүн	төгрөг	30,650,000

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, төсөв, хэрэгжүүлэх хугацаа болон давтамжийг тусгаж өгөв.

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН						
1.	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Салхи, шуурга ихтэй үед өрөмдлөг, тэсэлгээ, хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	Салхи шуурга ихтэй үеүдэд	-	Үйл ажиллагааны турш	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшний хэмжээ
2.		Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	Уурхайн ашиглалтын талбайд байнгын бэлэн байлгах	0.5	Үйл ажиллагааны турш	
3.		Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх	Хуурайшилттай үеүдэд /дотоод тээвэрлэлтийн зам дагуу/	2.5	Хуурайшилттай үеүдэд 7 хоногт 2 удаа	
4.		Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах	Гадаад, дотоод тээврийн зам	1.0	2026 онд	
5.		Уурхайгаас дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох	Гадаад, дотоод тээврийн зам	ҮАЗ-д тусгасан	Үйл ажиллагааны турш	

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
6.		Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Төсөлд ашиглагдаж буй техник хэрэгслүүд	ҮАЗ-д тусгасан	Үйл ажиллагааны туршид	
Дүн				4.0		
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ						
7.	Газрын гадарга эвдэрч, Хөрсний үржил шим алдагдах, бохирдох, эвдрэх, доройтох	Хөрс шатах тослох материалаар бохирдохоос сэргийлж автомашины засварын талбайг хатуу хучилттай болгох, аюулгүй ажиллагааг баримтлан ажиллах	Уурхайн засварын талбай	3.0	Тогтмол	Хөрс хамгаалах Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Газрын тухай хуулийн 50.1.1 MNS5914:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
8.		Хог хаягдлаар дамжин хөрсний бохирдол үүсгэхгүйн тул хог хаягдлын эцсийн цэгт хүргэх	Ахуйн хог хаягдлын цэг	Хог хаягдлын МТ-д тусгасан	2026	
9.		Машин техникийг маршрутын замаар явахыг хянах, зураг төслөөс гадуурх хөрс, талбайг хөндөхгүй байх	Үйл ажиллагааны турш дотоод хяналт хийх	ҮАЗ-д тусгасан	Үйл ажиллагааны туршид	
10.		Авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчих, олон салаа зам гаргахгүй байх, замыг тэмдэгжүүлэх	Уурхайн дотоод, гадаад тээврийн зам	ҮАЗ-д тусгасан	Үйл ажиллагааны туршид	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
11.	Ургамлан нөмрөг талхлагдахаас сэргийлэх	Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж био бэлдмэлээр тогтмол ариутгах, цаашид байгаль орчинд халгүй зайлуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	Хог хаягдлын МТ-д тусгасан	Улиралд 1 удаа	техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал
Дүн				3.0		
ГАЗРЫН ДООРХ УС						
12.	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар	Унд ахуй хангаж буй гүний худагт хяналт шинжилгээг явуулах	Уурхайн усан хангамж хангаж буй гүний худаг	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	Жилд 1 удаа	Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 30; Зүйл 31-1, 2, 3, 4, 5, 6, 8; Зүйл 33-1, 2, 3; Зүйл 34-1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998. БОНБНУ, Компанийн дотоод журам,
13.	усыг хэмжээгээр ашигласнаар усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах	Усны хэрэглээгээр	ҮАЗ-д тусгасан	2026 онд	
14.	Газрын доорх ус	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	Үйл ажиллагааны турш	Агаарын чанарын хэсэгт тусгасан	Үйл ажиллагааны турш	
15.		Бусад шаардлагагүй тохиолдолд гадаргын хэлбэр, төрх байдлыг өөрчлөхгүй байх		ҮАЗ-д тусгасан	Үйл ажиллагааны турш	



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Дүн				-		
АМЬТНЫ АЙМАГ						
20.	Малын бэлчээрийг доройтуулахаас сэргийлэх	Уурхайн тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх	Агаарын чанарын хэсэгт тусгасан	Агаарын чанарын хэсэгт тусгасан	Хуурайшилттай үеүдэд 7 хоногт 2 удаа	Амьтны тухай хууль
21		Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж био бэлдмэлээр тогтмол ариутгах, цаашид байгаль орчинд халгүй зайлуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	Хог хаягдлын МТ-д тусгасан	2026 онд	
Дүн				-		
НИЙТ				7.0 сая.төг		

4.2 Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

Ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” стандартад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэх ба нөхөн сэргээлтэнд шаардагдах зардлыг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тооцоолно.

Төслийн 2 дах жил болох 2026 онд уул техникийн нөхцлөөр техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэх боломжгүй тул төсөл хэрэгжих 4 дэх жилээс хийгдэнэ.

4.3 Тэрбум мод тарих арга хэмжээний төлөвлөгөө

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нь Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт жилд 100 ш мод тарина.

Хүснэгт 13. Байгалийн бүс бүслүүрийн харгалзан тарих мод, бутыг сонгох

№	Байгалийн бүс бүслүүр	Мод, бут	
1	Өндөр уулын бүс	Нарс, шинэс, улиас, улиангар, хус, бургас, монос, чацаргана, нохойн хошуу, шар хуайс, боролзгоно, голт бор	
2	Уулын тайгын бүс		
3	Ойт хээрийн бүс		
4	Хээрийн бүс	Нугын хээр	Хайлаас, бургас, монос, чацаргана, нохойн хошуу, шар хуайс, боролзгоно, голт бор
		Хээр	
		Хуурай хээр	
5	Говийн бүс	Цөлжүү хээр	Заг, тоорой, жигд, сухай, гүйлс, хармаг
		Заримдаг цөл	
6	Цөлийн бүс	Хээржүү цөл	
		Жинхэнэ цөл	
		Хэт гандуу цөл	

100 ш суулгац худалдан авах 500 мян.төгрөг бөгөөд ногоон байгууламжийн арчилгаа тордолгоо, усалгаа, тариалалтын зардалд 1 сая.төг, нийт 1.5 сая.төгрөг зарцуулагдана.

4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төслийн MV-017700 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

4.5 Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

4.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 9. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /сая.төг/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	Мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, дүгнэлтийг үндэслэн зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэх	Орон нутгийн саналын дагуу	-	-	8.0	2026 онд	
Нийт дүн, сая.төг						8.0	



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Болзошгүй аюул ослын анхааруулга, санамжийн самбар хийж, нүдэнд харагдахуйц шаардлагатай газарт байршуулах	1,500.0	2026 онд
	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	500.0	2026 онд
	Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах, засаж сайжруулах	1,000.0	2026 онд
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллах	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	1,000.0	Жил бүр, жилд 1 удаа
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	2,000.0	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	-Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгасан	Жил бүр, жилд 1 удаа
Нийт зардал		6,000.0	



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйг ээс орчин бохирдох	Хог хаягдлын гэрээг байгуулах	Үйл ажиллагааны турш	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Энгийн хог хаягдлын ангилан ялгадаг хогийн савыг кемп, үйлдвэрийн орчмын шаардлагатай газруудад байршуулах	Уурхайн хотхон	500.0	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах	1,000.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хог хаягдлын түр хадгалах цэгийг засаж сайжруулах /битүүмж сайтай, нэвчилт үүсэхээргүй, салхиар тархахааргүй, гадна тэмдэглэгээтэй/	Уурхайн хог хаягдлын түр хадгалах цэг	1,000.0	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	500.0	Төслийн эхэн үед	
	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Уурхайн ашиглалтын талбайд	500.0	Төслийн эхэн үед	
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй тохижуулах	Зориулалтын хог хаягдлын цэг	ҮАЗ-д тусгасан	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
			3.500,0		

4.9 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Тээлийн шонхор” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалан төлөвлөгөөтэй нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Тээлийн шонхор” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Тээлийн шонхор” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол						
1	Хөрсний агрохими хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа 3 цэгт	300,0	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никелийг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Хөрсний хүнд металлын агууламж	Хөрс хүнд металаар бохирдох, хөрс рүү нэвчих, гүний усыг бохирдуулах	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа 3 цэгт	350,0	
3	Хөрсний эрүүл ахуй, микробиологи	Хөрсөөр дамжин гэдэсний халдварт өвчин, нянгийн өвчнөөр өвчлөх	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа 3 цэгт	300,0	



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
НИЙТ 950.0						
Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ	Гүний худаг	Унд ахуйн ус хангаж буй гүний худаг 44° 37' 17.19" 110° 30' 53.98"	Жилд 1 удаа	350,0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
2.2	Усны чанар Микробиологи	Усны эрүүл ахуйн шинжилгээ		Жилд 1 удаа	350,0	MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
					НИЙТ 700.0	
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					1,650.0 мян.төг	



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ ДЭВЖИХИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	Үйл ажиллагааны хүрээнд	0.5	2026	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	Үйл ажиллагааны хүрээнд	1.5	2026	Уурхайн дотоод журам
Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ-д тусгасан	2026	Уурхайн дотоод журам
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ-д тусгасан	2026	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Нийгмийн хариуцлагын хүрээнд	1.0	Төслийн хугацаанд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Нийт, сая.төг			3.0	



4.11 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Тээлийн шонхор” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БОУАӨЯ болон Дорноговь аймгийн Байгаль орчны газарт	Цахимаар	Тухайн жилийн БОМТ-ийн хэрэгжилтийн тайлан	11-р сар	-	-